

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА ДАРГА НАРЫН 2023 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2023 оны 01 сарын 05 ний/ны өдөр

Мандалговь хот

Нэг.Гэрээний агуулга, зорилго

1.1. Дундговь аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний зорилго нь шударга, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлж, нутгийн захиргааны төрийн бүхий л байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгаж, Монгол улсын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах чиглэл, талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, эцсийн үр дүнг үнэлж, дүгнэх, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэхэд оршино.

1.2. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг удирдлага болгон нэг талаас Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат, нөгөө талаас **ЗДТГ-ын дарга Л.Доржбат** нар 2023 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулж, 2 хувь үйлдэв.

1.3. Уг гэрээ болон гэрээний хавсралтаар Дундговь аймгийн Засаг дарга болон **Дундговь аймгийн ЗДТГ-ын даргын** харилцан хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ, түүний тоо хэмжээ, чанарт тавих шаардлага, гэрээний биелэлтийг дүгнэх бусад нөхцөлийг тусгав.

1.4. Талуудын хооронд байгуулсан энэхүү гэрээтэй холбогдох харилцааг Монгол улсын Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжуудад нийцүүлэн зохицуулна.

1.5. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг (хавсралт) байна.

Хоёр. Аймгийн Засаг даргын хүлээх эрх, үүрэг

2.1. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлнэ.

2.2. Нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж төрөөс иргэдэд үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж, төсвийн үйл ажиллагааг ил тод болгоно.

2.3. Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймаг хөгжүүлэх 2021-2025 оны үндсэн чиглэл, аймгийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.

2.4. Төрийн бүх байгууллагад төсвийн зардлыг хэмнэх, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, удирдлага зохицуулалтаар хангана.

2.5. Нутгийн захиргааны байгууллагуудад чанарын менежментийн олон улсын стандарт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

2.6. Ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийн амьжиргааны түвшин дээшлүүлэхэд нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг хангаж ажиллана.

2.7. Нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудыг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.8. Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог тууштай хэрэгжүүлэх, төрийн албанд сахилга, хариуцлагыг чангатгах арга хэмжээ авна.

Гурав. Аймгийн ЗДТГ-ын даргын хүлээх эрх, үүрэг

3.1. Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж үр дүнг салбарын удирдлага, аймгийн Засаг даргын өмнө хариуцна.

3.2. Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, Монгол улсыг болон аймгийг 2020-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, салбарын болон аймгийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын зорилт, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан бүрэн хэрэгжүүлж ажиллана.

3.3. Аймгийн Засаг даргын Шадар сайдтай байгуулсан гэрээний 3.15-3.26 дэх заалтуудыг орон нутагт хэрэгжүүлэхэд хамтарч ажиллана.

3.4. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг шударга, ил тод, хүнд суртал чирэгдэлгүй удирдан чиглүүлж, ажлын сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгаж, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хамтран ажиллана.

3.5. Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог хэрэгжүүлж ажиллана.

3.6. Хуулиар олгосон чиг үүрэг, үйл ажиллагааны онцлог, стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө нийцүүлэн хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, шатлан дэвшүүлэх судалгаанд үндэслэн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөг албан тушаалын ангилал, зэрэглэлийн дагуу албан хаагч бүрээр 4 жилийн хугацаатай батлан хэрэгжүүлнэ.

3.7. Шилэн данс, цахим мэдээллийн ил тод, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, төсвийн сахилга батыг чанд баримтлан, төсвийн үр ашгийг сайжруулж ажиллана.

3.8. Гадаадын зээл тусламж, ОУБ-ын төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэх эдийн засаг нийгмийн үр ашигтай ажлыг хугацаанд нь зохион байгуулна.

3.9. Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгжийн саналыг авч Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн цагалбарыг баримтлан батлуулж ажиллана.

3.10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.11. Аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг шуурхай хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээ авна.

3.12. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж үйл ажиллагаа, үйлчилгээний чанарт ахиц дэвшил гаргана.

3.13. Төрийн албан хаагчидтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээг дүгнэхдээ тухайн албан хаагчийн иргэдэд үзүүлсэн үйлчилгээний тоо хэмжээ, чанарыг харгалзан дүгнэж, үүргээ хангалтгүй биелүүлсэн албан хаагчидтай хариуцлага тооцож ажиллана.

3.14. Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэн улирлаар тайлагнаж ажиллана.

3.15. Аймгийн Засаг даргаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай, чанартай зохион байгуулж ажиллана.

Дөрөв. Гэрээг дүгнэх

4.1. Аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор багтаан дүгнэнэ.

Тав. Бусад зүйл

5.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэж, албажуулан гэрээнд хавсаргана.

Дөрөв. Гэрээг дүгнэх

4.1. Аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлтийг 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг 06 дугаар сарын 15 ны дотор, сүүлийн хагас жилийг 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор багтаан дүгнэнэ.

Тав. Бусад зүйл

5.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэж, албажуулан гэрээнд хавсаргана.

5.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн тохиолдолд урамшуулах асуудлыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх, шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Төсвийн ерөнхийлөн захирагч

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
ГАЗРЫН




Ц.МӨНХБАТ

2023 оны ... дүгээр сарын ...-ны өдөр

Төсвийн шууд захирагч

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

2023 оны дүгээр сарын-ны өдөр

Төлөвлөгөө хянасан:

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

(албан тушаал)

Тэмдэг



Төсвийн Ерөнхийлөн захирагч

Ц.МӨНХБАТ

(гарын үсэг)


2023 оны 17 сарын 17 ний/ны өдөр

Төлөвлөгөөг баталсан:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

(албан тушаал)

Тэмдэг



Төсвийн шууд захирагч

Л.ДОРЖБАТ

(гарын үсэг)

2023 оны ... сарын ... - ний/ны өдөр

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт	Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээ	Зарцуулах хөрөнгийн хэмжээ /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
						Эхний хагас жил	Жилийн эцэс		
Стратеги төлөвлөгөөний зорилго: Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх замаар хүний хөгжлийн индекс 2019 онд 0.689 байгааг 2024 онд 0.719 хүргэнэ.									
НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД									
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС									
Зорилт	1	ТАХ-ийг чадавхжуулж орон нутагт дутагдалтай мэргэжлийн боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлнэ	-	Шинээр бэлтгэсэн боловсон хүчний тоо	35	10	30	I-IV улирал	ТЗУХ
				ТАХ-ыг чадваржуулах сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	92		150		
Арга хэмжээ	1.1	Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	ОНТ 750.0 сая	Хэрэгжилтийн хувь	90	-	92	II-IV улирал	ТЗУХ
	1.2	Байгууллагын албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	ОНТ 100.0 сая	Хэрэгжилтийн хувь	90		92	II-IV улирал	ТЗУХ

ДУНДГОВЬ АЙМАГ

	1.3	Засгийн газар болон аймгийн захиалгаар дотоод, гадаадад суралцагчидтай гэрээ хийж, орон нутагт нэн шаардлагатай боловсон хүчин бэлтгэх	ОНТ	Гэрээ байгуулсан оюутны тоо	35	10	30	I-IV улирал	ТЗУХ
	1.4	Хүний нөөцийн чадамжийн үнэлгээ хийж үнэлгээний дагуу сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилт үр дүнг тооцох	-	Чадамжийн үнэлгээ хийсэн эсэх /Тийм-1, үгүй-0/ Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	- 93	1 70	1 94	II улирал	ТЗУХ
Зорилт	2	Гадаадын муж хотуудтай шинээр холбоо тогтоон, хамтын ажиллагаатай муж хотуудтай байгуулсан гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг нэмэгдүүлнэ.	ОНТ	Арга хэмжээний тоо	3	2	4	I-IV улирал	ТЗУХ
Арга хэмжээ	2.1	ОХУ-ын Красноярск мужтай гэрээ байгуулах	ОНТ	Гэрээ байгуулсан эсэх /Тийм-1, үгүй-0/	0	-	1	I-IV улирал	ТЗУХ
	2.2	Төрийн албан хаагчдыг гадаадын улс оронд туршлага судлах арга хэмжээнд хамруулах	ОНТ	Туршлага судалсан албан хаагчдын тоо	5	-	7	I-IV улирал	ТЗУХ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС									
Газар тариалангийн бодлого зохицуулалт:									
Зорилт	1	Орон нутгийн хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээний 19,5 хувийг хангана.	Төсөл хөтөлбөр 63,7	Хангамжийн хувь	19,1	-	19,5	II-IV улирал	ХБТХОХ
Арга хэмжээ	1	Тариалан эрхлэгчдэд технологийн сургалт зохион байгуулах	-	Тухайн жилд зохион байгуулах сургалтын тоо	4	-	2	II-IV улирал	ХБТХОХ
				Нэмэгдүүлсэн механикжуулалтын тоо	0	-	2	II-IV улирал	ХБТХОХ
	2	Төмс, хүнсний ногоо тариалсан талбай болон хураан авсан ургацын хэмжээг нэмэгдүүлэх	-	Тариалсан талбайн хэмжээ /га/	29,4	-	30	II-IV улирал	ХБТХОХ
				Хураан авсан ургацын хэмжээ /тн/	234,4	-	235	II-IV улирал	ХБТХОХ
Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого зохицуулалт:									
Зорилт	1	Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын чанар, стандартыг сайжруулна.	Хувийн хэвшил, төсөл	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин	-	60	70	I-IV улирал	ХБТХОХ
				Стандартын	70	75	80	I-IV улирал	

ДУНДГОВЬ АЙМАГ

			хөтөлбөр	хэрэгжилтийн хувь					
Арга хэмжээ	1.1	Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх аж ахуй нэгжид тусгай зөвшөөрөл олгох, сунгах ажлыг зохион байгуулах	-	Тусгай зөвшөөрөл олгосон эсэх /Тийм-1, үгүй-0/	1	1	1	I-IV улирал	ХБТХОХ
				Тусгай зөвшөөрөл сунгасан эсэх /Тийм-1, үгүй-0/	1	1	1	I-IV улирал	
	1.2	Худалдаа, үйлчилгээний ажилтнуудын мэргэжил дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, ажил мэргэжлийн уралдаан, зэрэг арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	-	Зохион байгуулсан сургалтын тоо	1	-	1	II-IV улирал	ХБТХОХ
				Мэргэжлийн уралдаан зохион байгуулсан тоо	1	-	1	II-IV улирал	
1.3	Тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн судалгааг гарган аймгийн сайтад тухай бүр ил тод мэдээлж байх	-	Сайтад мэдээлсэн тоо	1	2	3	II-IV улирал	ХБТХОХ	
Хөнгөн, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны хөгжлийн бодлого, зохицуулалт:									
Зорилт	1	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарт дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, жижиг дунд, хөнгөн, хүнсний үйлдвэрийн тоо 2022 онд 51 байгааг 2023 онд 53 болгоно	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Тухайн жилийн үйлдвэрийн тоо	51	-	2	II-IV улирал	ХБТХОХ
Арга хэмжээ	1.2	“Дундговь түншлэл-2023” үзэсгэлэн худалдааг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах	Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Тухайн жилийн оролцогчдын тоо	260	-	100	II-IV улирал	ХБТХОХ
				Тухайн жилийн борлуулалтын орлого /сая,төг/	72,9	-	85	II-IV улирал	
	1.3	Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх	ЖДҮСан	Тухайн жилийн санхүүжилт нэмэгдсэн эсэх /Тийм-1, үгүй-0/	1	-	1	II-IV улирал	ХБТХОХ
	1.4	“Хоршоог хөгжүүлэх сан”-ийн эргэн төлөлтөд хяналт тавих	ХХСан	Тухайн жилийн зээлийн эргэн төлөлтийн хувь нэмэгдсэн эсэх /Тийм-1, үгүй-0/	1	-	1	II-IV улирал	ХБТХОХ

	1.5	Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт хийх	ЖДҮСан	Хяналт хийсэн тоо /Тийм-1, үгүй-0/	0	-	1	II-IV улирал	ХБТХОХ
Мал аж ахуйн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах:									
Зорилт	1	Малын тоог чанарт шилжүүлж биотехнологийн ололтыг 1100 малд нэвтрүүлнэ.	ОНТ 40 сая	Хамрагдсан малын тоо	1030	-	1100	II-IV улирал	ХБТХОХ
Арга хэмжээ	1.1	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулах		Төлөвлөгөө батлуулсан эсэх /1-тийм, 0-үгүй/	0	-	1	II-IV улирал	ХБТХОХ
	1.2	Нутгийн шилмэл хонинд зохиомол хээлтүүлэг хийхэд мэдлэг арга зүйн зөвлөгөө өгөх	--	Зөвлөгөө өгсөн тоо	0	-	1	II-IV улирал	ХБТХОХ
Зорилт	2	Талхлагдсан 110,0 мянган га бэлчээрийн талбайг сэргээх, усан хангамжийг нэмэгдүүлнэ.	ОНТ-30,0 сая, Төсөл хөтөлбөр-80,0сая	Тухайн жилд сэргээсэн талбайн хэмжээ /га/	129.6	5	10	I-IV улирал	ХБТХОХ
				Усан хангамж нэмэгдүүлсэн хувь	1,5	-	1	I-IV улирал	
Арга хэмжээ	2.1	Тэжээлийн олон наст ургамал тариалах хүсэлтэй иргэдийг сургалтад хамруулах	ОНТ-30,0 сая, Төсөл хөтөлбөр-80,0сая	Зохион байгуулсан сургалтын тоо	0	-	2	I-IV улирал	ХБТХОХ
	2.2	Гүн өрмийн худгийг шинээр гаргуулахаар төсөл хөтөлбөр болон орон нутгийн төсөвт тусгуулах		Хамрагдсан иргэдийн тоо	42	-	50	II-IV улирал	ХБТХОХ
	2.3	Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулах аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах		Төлөвлөгөөний хэрэгжилт хувь	84	-	85	II-IV улирал	ХБТХОХ
Ногоон байгууламжийн бодлого хэрэгжүүлэх									
Зорилт	1	Ногоон байгууламжийн талбайн хэмжээг өмнөх оноос нэмэгдүүлнэ	УТ- 90.0 ОНТ- 240.0	Нэмэгдсэн талбайн хэмжээ /га/	381.4	387.4	392.4	II,IV улирал	ХБТХОХ

ДУНДГОВЬ АЙМАГ

Арга хэмжээ	1.1	Орон нутгийн хөрсөнд дасан зохицсон тарьц, суулгац бэлтгэх мод үржүүлгийн газар шинээр байгуулах	50.0 ОНТ	Шинээр байгуулсан мод үржүүлгийн газрын тоо	1	-	1	II,III,IV улирал	ХБТХОХ
	1.2	Ногоон байгууламжийн хэмжээ 2022 онд 412.4 га байсныг 2023 онд 417.4 га болгон нэмэгдүүлнэ.	ОНТ 122.5 Хувийн хэвшил 50.0	Ногоон байгууламжийн хэмжээ (га)	412.4	417.4	417.4	II,III,IV улирал	ХБТХОХ
	1.3	“Дундговио ногооруулъя” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх	100.0 ОНТ	2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	83.2	84	85	II,III,IV улирал	ХБТХОХ
Аялал жуулчлалын бодлого хэрэгжүүлэх									
Зорилт	1	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн гадаад, дотоод жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	ОНТ 100.0	Дундговь аймагт ирсэн гадаад, дотоод жуулчдын тооны өсөлт /сая.төг/	23.0	27.0	31.0	I-IV улирал	ХБТХОХ
Арга хэмжээ	1.1	Цагаан суварга, Их газрын чулууны отоглох цэгийг орон нутгийн өмчид бүртгэж хүлээн авах	90.0 УТ	Бүртгэлжүүлсэн отоглох цэгийн тоо	0	-	2	I-IV улирал	ХБТХОХ
	1.2	Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент (Тэмээчний өв соёлын баяр, Адуучин, айрагны баяр) арга хэмжээг хамтран зохион байгуулах	ОНТ 30.0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	1	2	I-IV улирал	ХБТХОХ
	1.3	“Ай Ти Эм” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд нэгдсэн байдлаар зохион байгуулалттай оролцуулах	5.0 ОНТ	Оролцсон аж ахуй нэгж, иргэний тоо	8	-	10	I-IV улирал	ХБТХОХ
Орчны бохирдлыг бууруулах									
Зорилт	1	Төв суурин газрын орчны бохирдлын түвшинг бууруулна.	УТ- 434.0	Агаарын чанарын индексийн түвшин	0	-	100>	I-IV улирал	ХБТХОХ
				Хөрсний бохирдлын бууралтын хувь	16	-	16>		
Арга	1.1	Агаарын чанарыг сайжруулах бүсэд			90	-	90	I-IV улирал	ХБТХОХ

ДУНДГОВЬ АЙМАГ

хэмжээ		мөрдөх журмыг хэрэгжүүлэхэд хяналт тавих		Хэрэгжилтийн хувь					
	1.2	Агаарын бохирдлын эсрэг "Монгол гэрийн халаалт, дулаалга, агаар сэлгэлтийн багц" чип төслийг хэрэгжүүлэх	156.8 НҮБ-ын хүүхдийн сан	Чип багц суурилуулсан өрхийн тоо	0	20	40	III-IV улирал	ХБТХОХ
	1.3	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах 3R цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн эргэлтэд оруулахад хяналт тавих	Орон нутгийн төсөв	Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгасан хэмжээ (тн)	40	41	42	I-IV улирал	ХБТХОХ
	1.4	Сумын хэмжээнд гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн ландфилл байгуулахад хяналт тавих	Орон нутгийн төсөв	Төвлөрсөн цэгийн тоо	0	-	1	I-IV улирал	ХБТХОХ
Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах									
Зорилт	1	Усны бохирдол, хомсдолоос сэргийлж, шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.	210.0	Цэвэршүүлсэн усаар хангагдсан хүн амын эзлэх хувь өссөн дүнгээр	36	-	36<	I-IV улирал	ХБТХОХ
Арга хэмжээ	1.1	Төв суурин газрын ундны усны чанар стандартыг сайжруулах ажлын хэсгийн үйл ажиллагааг идэвхжүүлж төлөвлөгөө боловсруулан ажиллах	-	Төлөвлөгөө боловсруулсан эсэх /Тийм-1, Үгүй-0/	0	1	1	I-IV улирал	ХБТХОХ
	1.2	Олгойн говийн 1 дүгээр гүний худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж байршуулах	ОНТ-180.0 Гадаадын хөрөнгө оруулалт 700.0	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь Ус цэвэршүүлэх төхөөрөмж байршуулсан эсэх /Тийм-1, Үгүй-0/	0 0	- -	100 1	II-IV улирал	ХБТХОХ
Уул уурхайн бодлого хэрэгжүүлэх									
Зорилт	1	Уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээ 2022 онд 25 байсныг 2023 онд 27 болгон нэмэгдүүлнэ.	-	Хамтран ажиллах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо	25	26	27	I-IV улирал	ХБТХОХ
Арга хэмжээ	1.1	"Уул уурхайн зөвлөгөөн 2023" арга хэмжээг зохион байгуулах	ОНТ10.0	Зөвлөгөөн зохион байгуулсан эсэх /тийм-1, үгүй-0/	1	1	1	II улирал	ХБТХОХ

	1.2	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа хяналт шалгалт явуулах	ОНТ 5.0	Тухайн жилд хийсэн хяналт шалгалтын тоо	1	1	2	I-IV улирал	ХБТХОХ
	1.3	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүдэд орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан таниулж, бүтээгдэхүүн нийлүүлэх	-	Нийлүүлсэн бараа бүтээгдэхүүний нэр төрөл	-	1	2	I-IV улирал	ХБТХОХ
	1.4	"Нөхөн сэргээлт-2024" нэгдсэн арга хэмжээнд хяналт тавих	ОНТ	Хяналт тавьсан тоо	-	-	1	II-IV улирал	ХБТХОХ
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд									
Зорилт	1	"Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх	300 сая ОНТ	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	2	2	2	I-IV улирал	ХБТХОХ
Арга хэмжээ	1.1	"Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж батлуулах	-	Төлөвлөгөө батлуулсан эсэх	1	1	-	I улирал	ХБТХОХ
	1.2	Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын дэд ажлын хэсгийн төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэх	300 сая ОНТ	Төлөвлөгөө батлуулсан эсэх	1	1	-	I улирал	ХБТХОХ
				Хэрэгжилтийн хувь	-	40	80	I-IV улирал	ХБТХОХ
1.3	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг байгуулах	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	3	2	2	I-IV улирал	ХБТХОХ	
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС									
Зорилт	1	Төсвийн ил тод байдал, төсвийн хяналтыг сайжруулан төсвийн үр ашгийг дээшлүүлнэ.	ОНТ	Нийт зардалд орон нутгийн орлогын эзлэх хувь	36.4	38.0	41.0	I-IV улирал	СТСХ
Арга хэмжээ	1.1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөл, 2025-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулан Сангийн яаманд хянуулах, 2024 оны төсвийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулах	ОНТ	Төсөв хуулийн хугацаанд батлагдсан эсэх /Гийм-1, үгүй-0/	1	1	1	IV улирал	СТСХ

ДҮНДГОВЬ АЙМАГ

	1.2	Төсвийн шууд болон төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланг бэлтгэн хуулийн хугацаанд аудитад оруулах, олон нийтэд мэдээлэх	ОНТ	Зөрчилгүй дүгнэлттэй байгууллагын эзлэх хувь	87.2	89.0	89.0	I-IV улирал	СТСХ
			ОНТ	Олон нийтэд мэдээлсэн байгууллагын тоо	78	85	85	I-II улирал	
	1.3	Төсвийн зарлагын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгох, төсвийн сарчилсан хуваарьт журмын дагуу зохицуулалт хийх ажлыг зохион байгуулах	ОНТ	Хуваарийн дагуу санхүүжилт олгогдсон эсэх /Тийм-1, үгүй-0/	1	1	1	I-IV улирал	СТСХ
	1.4	Аймгийн төрийн сан болон сумдын санхүүгийн албанд төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх	ОНТ 4.0	Тухайн жилд хяналт хийх сумын тоо	15	4	5	I-IV улирал	СТСХ
				Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	88,5	80	90	I-IV улирал	
	1.5	Төсөв захирагч нарыг чадавхжуулах сургалтыг бүсчилж танхимаар зохион байгуулах	ОНТ 20.0	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	-	200	200	I-II улирал	СТСХ, ТАГ
	1.6	"Татвар төлөгч Танд баярлалаа" аян зохион байгуулах	ОНТ 20.0	Арга хэмжээнд хамрагдсан татвар төлөгчийн тоо	-	400	400	I-II улирал	СТСХ ТХ
1.7	Төрийн сангийн удирдлагын цахим системийг нэвтрүүлж төрийн сангийн төлбөр тооцоог цахимжуулах	УТ, ОНТ	Цахимжуултанд хамрагдсан байгууллагын тоо	136	152	152	I-II улирал	СТСХ	
Зорилт	2	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг нэмэгдүүлнэ.	ОНТ	Шилэн дансны хэрэгжилтийн хувь	95	95	96	I-IV улирал	СТСХ
Арга хэмжээ	2.1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэж сангийн яамны Төрийн сангийн газар, Статистикийн хэлтэст хүргүүлэх, Шилэн дансанд байршуулах	ОНТ	Мэдээлэх тоо	12	12	12	I-IV улирал	СТСХ
	2.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн 2022 оны төсвийн гүйцэтгэлийг ИТХ-аар батлуулах ажлыг зохион байгуулах	ОНТ	2022 оны төсвийн гүйцэтгэлийг ИТХ-аар баталгаажуулсан эсэх /Тийм-1, үгүй-0/	1	1	1	IV улирал	СТСХ
	2.3	Аймгийн 2023 оны төсвийн мэдээллийг иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар бэлтгэн, хэвлүүлэх, олон нийтэд мэдээлэх	ОНТ 2.5	"Иргэдийн төсөв" бэлтгэсэн эсэх /Тийм-1, үгүй-0/	0	1	1	I-IV улирал	СТСХ
Мэдээлэл хүргэсэн сувгийн					30	30	I-II улирал		

				тоо					
				Хэвлэсэн тоо	-	500	500	I-II улирал	
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС									
Зорилт	1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг өмнөх оноос нэмэгдүүлнэ.	-	Үр дүнгийн үнэлгээний дундаж хувь	77.9	80	80	I улирал	ХШҮХ
Арга хэмжээ	1.1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	1	1	1	I улирал	ХШҮХ
	1.2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх	-	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	1	1	1	I улирал	ХШҮХ
	1.3	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	1	1	1	I улирал	ХШҮХ
	1.4	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	1	1	1	I улирал	ХШҮХ
	1.5	Эдийн Засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээний үзүүлэлтийн жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх	-	Хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн тоо	1	1	1	I улирал	ХШҮХ
	1.6	Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн төлөвлөгөөний тоо	18	18	18	I улирал	ХШҮХ
	1.7	Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн тоо	1	1	1	I улирал	ХШҮХ
	1.8	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн	-	Хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн тоо	1	1	1	I улирал	ХШҮХ

ДУНДГОВЬ АЙМАГ

		баталгааны хөтөлбөрийн жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх							
	1.9	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	1	1	1	I улирал	ХШҮХ
	1.10	Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн жилийн эцсийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	1	1	1	I улирал	ХШҮХ
ЦЭРГИЙН ШТАБ									
Зорилт	1	Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж, хэрэгжилтийг нэмэгдүүлнэ.	-	Хамрагдалтын хувь	80	-	82	I-IV улирал	ЦШ Сумдын ЗД
лАрга хэмжээ	1.1	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийн сургалтыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэх	4,5 ОНТ	Сургалтад хамрагдсан болон бүтээн байгуулалтын ажилд оролцсон иргэдийн тоо	35	35	35	II-III улирал	Цэргийн штаб
	1.2	"Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг ханган, гамшгийн хөнөөх хэрэгслээс хамгаалах сумангийн томилгоот нэгжийн сургалтыг зохион байгуулах	8,0 ОНТ	Хамрагдах иргэдийн тоо	0	33	-	II улирал	Цэргийн штаб
	1.3	Хугацаат цэргийн албаны цэрэг халалт, татлагыг зохион байгуулах	23,0 ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	1	2	II-III улирал	Цэрэг татлагын комисс
	1.4	Аймгийн 2023 оны цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулах	-	Хэрэгжилтийн хувь	82,7	85	85	I улирал	Цэргийн штаб, сумдын ЗД
	1.5	Нууц баримт бичиг, бусад нууц тээгчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд нэг бүрчлэн тооллого хийж, шалган	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	1	2	II,IV улирал	ЦШ

		хадгалалт хамгаалалтын байдал, цаашид авах арга хэмжээний талаарх санал, дүгнэлтийг тусган акт үйлдэж нэг хувийг Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэх							
	1.6	Зэвсэгт хүчний 102 жилийн ой, чөлөөлөх дайны 78 жилийн ойн баярын арга хэмжээг тусгай төлөвлөгөөгөөр зохион байгуулах	2,0 ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	3	3	3	I улирал	ЦШ
ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД									
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС									
Зорилт	1	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ дээшилсэн байна.	-	Хэрэглэгчийн үнэлгээний хувь	50	55	60	I-IV улирал	ТЗУХ
Арга хэмжээ	1.1	Сум, байгууллагуудын мэдээллийн ил тод байдалд үнэлгээ хийх	-	Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээний хувь	55,8	60	65	I-IV улирал	ТЗУХ
			-	Үнэлгээ хийсэн тоо	1	1	2	I-IV улирал	ТЗУХ
	1.2	Засгийн газрын 11-11 төвөөс хуваарилагдсан болон 7059106 утсанд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн хяналтад авхуулж, шийдвэрлэлтэд хяналт тавих	-	ӨГСХ-ийн шийдвэрлэлтийн гүйцэтгэлийн хувь	-	80	80	I-IV улирал	ТЗУХ
	1.3	Засаг даргын шуурхай хуралдааныг хуваарийн дагуу зохион байгуулах	-	Тогтсон хуваарийн дагуу журмын дагуу зохион байгуулах тоо	0	12	24	I-IV улирал	ТЗУХ
	1.4	Аймгийн хэмжээний мэдээ, мэдээллийг албан ёсны сайт www.dundgovi.gov.mn сайт, "Дундговь аймаг Засаг даргын Тамгын Газар" фэйсбүүк хуудсанд тогтмол нийтлэх	-	Сайтад нийтэлсэн мэдээ, мэдээллийн тоо	820	400	1000	I-IV улирал	ТЗУХ
			Фэйсбүүк хуудсанд нийтэлсэн мэдээ, мэдээллийн тоо	1600	800	2000			
	1.5	Сайт, сонин, телевиз зэрэг орон нутгийн болон төвийн хэвлэл	-	Мэдээ, мэдээллийг түгээсэн сувгийн тоо	3	4	5	I-IV улирал	ТЗУХ

ДУНДГОВЬ АЙМАГ

		мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, аймгийн хэмжээний онцлох мэдээ, мэдээллийг сурталчлах		Гэрээт Сайт, сонин, телевизээр дамжуулсан мэдээ, мэдээллийн тоо	10	15	30		
	1.7	Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх хугацааг бууруулах	-	Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэх хугацааны бууралт	30	28	27	I-IV улирал	ТЗУХ
	1.8	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг иргэдэд сурталчлах		Иргэдэд хүргэсэн мэдээллийн тоо	2	1	2	I-IV улирал	ТЗУХ
	1.9	Иргэдтэй хийх уулзалт хэлэлцүүлгийн хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	-	Иргэдтэй хийсэн уулзалт хэлэлцүүлгийн тоо	7	12	19	I-IV улирал	ТЗУХ
Хамрагдсан иргэдийн тоо				4000	3000	6000			
Уулзалт хэлэлцүүлгийн үеэр гарсан ӨГСХ-ийн шийдвэрлэлтийн хувь				70	68	73			
	1.10	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авч, гарсан саналыг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжилт үр дүнг ЧУХ-д танилцуулах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	-	75	I-IV улирал	ТЗУХ
ЧУХ-д танилцуулсан эсэх (Тийм-1, үгүй-0)				-	-	1			
Зорилт	2	Цахим шилжилт-Цахим Дундговь" цахим шилжилтийн хэрэглээг нэмэгдүүлэх	-	Цахим шилжилтийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь хувь	80	60	90	I-IV улирал	ТЗУХ
